



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Удирдлагын академийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2009 оны 06/94/814 дүгээр дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, 186,185,877.15 (нэг зуун наян зургаан сая нэг зуун наян таван мянга найман зуун далан долоон төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 145,069,829.60 (нэг зуун дөчин таван сая жаран есөн мянга найман зуун хорин есөн төгрөг жаран мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, ашиглаж болох материалыг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлөгдсөн газарт Улсын төсвийн санхүүжилтээр Удирдлагын академийн төрийн өмчийн кампус, өргөтгөлийн барилгыг барих;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан тайлagnах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001363

Төрийн юмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11.-дугаар сарын 11.-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нийт талбай /мкв/	Ашиглаж нийт хугацаа /жилээр/	Балансын нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Удирдлагын ажлын дотуур байрны барилга	12/31/1956	3810	60	186,185,877.15	145,069,829.60	41,116,047.55
	НИЙТ ДҮН				186,185,877.15	145,069,829.60	41,116,047.55
	(Нэг зуун наян зургаан сая нэг зуун наян таван Мянга найман зуун дэлжин долоон төгрөг арван таван мөнгө)				(Нэг зуун наян зургаан сая нэг зуун наян таван Мянга найман зуун дэлжин долоон төгрөг арван таван мөнгө)		(дөчин нэгэн сая нэг зуун арван зургаан мянга дөчин долоон төгрөг таван мөнгө)